

УСАН БАТАЛГААНЫ АМЛАЛТЫГ ДАХИН БАТАЛГААЖУУЛАХ ЁСЛОЛ БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ТАЛАРХАЛ БА ҮГИЙН ҮЙЛЧЛЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР БОЛОН САНААНУУД

Ням гарагийн Христ итгэлт хүндэтгэл мөргөлийн цугларалтад цуглах эсвэл усан баталгааг баталгаажуулах ёслол, усан баталгааны тангарга гэх мэт бусад үндсэн үйлчлэлийн үед дараах дэс дарааллыг баримтална.

*Эдгээр нь хүндэтгэл мөргөлийн үйлчлэл хийхээр төлөвлөж буй хүмүүст хөтөч болох зорилготой болохоос чуулганы заавал сахих ёстой журам **биш**. Чуулганы үйл ажиллагааны тайлбарыг зарлал, тараах материал, дижитал проектороор дамжуулан хийж болно.*

Тухайн пастор өөрийн үнэлэлт дүгнэлтээр орон нутгийн онцлог, уламжлалт соёлыг үйлчлэлдээ тусгаж болно. Бурханы Үгийг тунхаглах болон итгэгчдийн хариу үйлдлийг илэрхийлэхийн тулд бүжиг, хөгжим, төрөл бүрийн урлагийн хэлбэр жанрыг ашиглаж болно.

ЭХЛЭЛ

ЦУГЛАРАЛТ

Хүмүүс хамтдаа Эзэний нэр дээр цугларна.

Тэд цугларч байх хооронд дараах зүйлсийн аль нэгийг нь эсвэл түүнээс олныг хэрэгжүүлж болно. Үүнд:

Мэдээллийн цугларалт, харилцан ярилцлага, нөхөрлөл

Зарлал, угтан авалт

Магтаалын хөгжим болон бусад хэлбэрийн магтаал хүндэтгэлийн бэлтгэл,

Албан бус залбирлууд, дуулалт, гэрчлэл

Чимээгүй бясалгал, хувийн залбирал

Хөгжимт, аман хөгжим болон бүжиг

Цугласан олонд хандан, удирдагч Эзэний нэр дээр мэндчилнэ.

Мэндчилгээнд дараах зүйлс орж болно. Үүнд:

Бичээсийн үг хэллэгүүд эсвэл Эзэн бидэнтэй хамт бөгөөд бидний хүндэтгэлийг хүчирхэгжүүлж буйг тунхагласан итгэгчид болон удирдагчдын хооронд харилцан үйлдэл. Эзэн бидэнтэй хамт байж мөргөлийг хүчирхэгжүүлдэг.

Бидний амьдралыг усан баталгааны амлалт руу эргэн дуудаж буйг илэрхийлэхээр цөгц рүү ус цутгах ёслол

Мэндчилгээний дуу болон магтан дуу

МЭНДЧИЛГЭЭ

Эзэн Есүс Христийн нигүүлсэл тантай хамт байх болтугай

Тантай ч бас хамт байх болтугай .

Дээш өргөгдсөн Христ бидэнтэй хамт.

Эзэнийг магтагтун!

МАГТААЛ

Хүмүүс хамтдаа Бурханыг магтана.

Дараахын аль нэгийг эсвэл түүнээс олныг дуулж, хэлж болно. Үүнд:

Магтаалын дуу болон магтуу.

Чуулганаар магтах магтаалыг хөгжмийн зэмсэг оролцуулж, төрөлжүүлэх

Тухайн өдрийн нийтийн залбирал

Нүглээ наманчлах улирал болох мацаг барилт гэх мэт үед ялангуяа хийгддэг нүглээ

улайх залбирал, хүлцэл өчих залбирал. Хэрэв гэмээ улайх болон гэмших цаг

явагдчихсан бол энэ цугларалт дээр дахин давтан хийх шаардлагагүй.

"Эзэн өршөөг" буюу "Kyrie, eleison" эсвэл "Өндөрт Бурханд алдар нь" хэмээн

удирдагчийн хэлснийг нийтээрээ давтан хэлэх

Дуулал эсвэл бичээс дээрх дуу

Глориа Патри буюу Эцэгт алдар нь байг

Сүлд дуу

Бүх чуулганыг хамруулсан бусад төрлийн уран сайхны илэрхийлэмж

ҮГ БОЛОН ТҮҮНД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

Хүмүүс зүрх сэтгэл, оюун бодлоо Бурханы Үгийг сонсоход бэлтгэнэ.

Пастор эсвэл хүндэтгэлийн удирдагч Бурханы Үгийг уншиж, номлож, сонсож, хэрэгжүүлэхэд удирдах Ариун Сүнсний адислалыг авахад цугласан олныг удирдана.

ТАЙЛБАРЛАН ТАНИУЛАХЫН ТӨЛӨӨХ ЗАЛБИРАЛ*

Эзэн, Өөрийн Ариун Сүнсний хүчээр

Бидний зүрх сэтгэл, оюун бодлыг нээгээч

Бичээсүүдийг уншиж,

Таны үг тунхаглагдах үед

Өнөөдөр бидэнд хэлэгдэх таныг үг бүрийг баяр хөөртэйгөөр

Чих тавин сонсох болтугай. Амен.

БИЧЭЭС

Чангаар уншигдах Бурханы Үгийг хүмүүс сонордоно.

Жирийн хүмүүс Хуучин Гэрээ болон Элч нарын уншлагыг уншиж Дуулал номноос залбирал үйлддэг уламжлалтай. Пастор номлолтой холбогдох сайн мэдээний номноос болон бусад ишлэлээс уншиж болно.

Хоёр эсвэл гурван бичээсийн уншлага ашиглагдана. Шинэчлэгдсэн Нийтлэг Товхимол нь эдгээр уншлагын гол эх сурвалж байна. Хэрэв үйлчлэл бүрт Хуучин Гэрээ, Элч нарын болон Сайн мэдээний уншлагууд байхгүй бол тухайн цагт тус бүрээс төлөөлүүлэн уншлагыг сонгон авч хүмүүс сонсоно.

Бичээсийн уншлагууд нь дараах төрлүүдээр байж болно. Үүнд:

Дуулал эсвэл дууллын нэг хэсэг, дуу эсвэл үгэн хэлбэрээр, эхний уншлагын дараа

Тухайн өдрийн номлолын ишлэлтэй холбоотой магтуу дуу, дуу эсвэл бусад урлагийн илэрхийлэмж
Хэрэв энэ нь сайн мэдээний тухай бол сүүлийн уншлагын өмнө эсвэл дараа Халлелүяа дуулах

Илчлэлт 7:9-17 (Библийн шинэчлэн зассан стандарт хувилбар)

7:9 Харагтун, үүний дараа намайг харахад, сэнтийн өмнө болон Хурганы өмнө зогсон, цагаан дээл өмссөн, гартаа далдуу модны найлзуур барьсан, үндэстэн бүрээс, бүх овгоос, бүх ард түмнээс, бүх хэлтнээс ирсэн үй олон хүн байв. Хэн ч тэднийг тоолж чадамгүй ажээ. Тэд чанга дуугаар

-Аврал бол сэнтийд залрагч бидний Бурханд ба Хурганд байдаг гээд хашхирч байлаа.

Сэнтий, ахлагчид болон дөрвөн амьтны эргэн тойронд бүх тэнгэр элч нар зогсож байлаа. Тэд сэнтийн өмнө нүүрээрээ унаад Бурханд мөргөж,

-Амен. Магтаал, алдар, мэргэн ухаан, талархал, хүндэтгэл, хүч чадал ба сүр хүч нь бидний Бурханд үеийн үед байх болтугай. Амен гэгцгээв.

Ахлагчдын нэг нь хариулж, надад хандан

-Цагаан дээлтэй эдгээр хүмүүс хэн бэ? Тэд хаанаас ирсэн бэ? гэлээ. Би түүнд

-Эзэн минь, та мэднэ гэхэд тэр надад -Эдгээр нь үлэмж их зовлонгоос гарч ирэгсэд бөгөөд тэд Хурганы цусаар дээлээ угааж, цагаан болгожээ. Тиймээс тэд Бурханы сэнтийн өмнө байдаг бөгөөд Түүний сүм дотор өдөр шөнөгүй Түүнд үйлчилдэг юм. Сэнтийд Залрагч асраараа тэднийг дээгүүр нь бүрхэнэ. **Тэд цаашид өлсөх ч үгүй, цангах ч үгүй. Тэд наранд шарагдах ч үгүй, ямар ч халуунд халах ч үгүй. Яагаад гэвэл сэнтийн голд байгаа Хурга тэднийг хариулах бөгөөд амийн усны булгууд уруу хөглөх болно. Бурхан тэдний нүднээс урсах нулимс бүрийг арчих болно гэлээ.**

Энэ бол Эзэний үг.

ЭЗЭН Бурханд талархал нь байх болтугай!

НОМЛОЛ

Номлогч эсвэл бусад эрх бүхий удирдагч бичээсээс Бурханы Үгийг тунхаглаж хүмүүсийн сонорт уншиж өгнө.

Бичээсээс нэг эсвэл түүнээс олон ишлэл иш татагдаж Бурханы ажлын тухай гэрчлэлийг тунхаглана.

ҮГЭНД ҮЗҮҮЛЭХ ХАРИУ ҮЙЛДЭЛ

Пастор болон бусад нь хүмүүсийг сонсож тунхаглагдсан Бурханы Үгэнд хариу үйлдэл үзүүлэхэд удирдана.

Хариу үйлдэл нь дараахийн аль нэг эсвэл түүнээс олон нь байж болно. Үүнд:

Христчин дагалдагч болоход уриалах, араас нь урилга буюу хариу үйлдлийн тухай эсвэл усан баталгаа болон баталгаажуулалтын тухай магтуу дуу дагалдах

Баптисмын Амлалтын тодорхой хэсгүүд:

Ариун Усан Баталгаа

Баталгаажуулалт

Усан баталгааны Амлалтын дахин баталгаажуулалт

Нэгдсэн Методист Цуглаанд хүлээн авах

Орон нутгийн чуулганд хүлээн авах

Хүмүүсийн амьдралд биелэгдсэн Бурханы үйлсийн талаарх гэрчлэл

Баптисмын Амлалт өгөхөд хэрэглэснээс гадна итгэлийн тунхаг

АМЛАЛТ IV

ЧУУЛГАН БҮХЭЛДЭЭ БАПТИСМЫН АМЛАЛТАА БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Энэхүү ёслолын үйл ажиллагаа нь усан баталгаа хүртэх, баталгаажуулах эсвэл усан баталгаа хүртээхээр хүлээж авах болон гишүүн болгох тодорхой нэр дэвшигчгүй байх үед буюу тэр дундаа Дахин амилсны баярын өдөр, Дээгүүр өнгөрөх баяр, Бүх элч нарын баярын өдөр болон Эзэний усан баталгаа хүртсэн өдрүүдэд бүх нийтээрээ өргөх хүндэтгэлд зориулагдана.

ҮЙЛЧЛЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хүндэтгэлийн удирдагч эсвэл пастор цугласан олонд хандан ийнхүү хэлнэ.

Христ доторх ах, эгч дүүс нар аа,

Усан баталгааны тангаргаар дамжуулан бид Христийн ариун Сүмийн нэгэн хэсэг болсон билээ.

Ийнхүү бид Бурханы авралын сүр хүчит үйлсэд нэгдэн орж Ариун Сүнс болон усаар шинэ амийг олсон юм.

Энэ бүхэн бол бидэнд үнэгүй өгөгдсөн Бурханы бэлэг мөн.

Бид итгэлээ дахин баталгаажуулснаар усан баталгаа хүртэх үедээ тунхагласан амлалтаа шинэчилж буй хэрэг юм. Ингэснээр Бурханы бидний төлөө хийсэн бүхнийг бүрэн хүлээн зөвшөөрч Христийн ариун Сүмд өөрсдийн үүргийг бататгадаг билээ.

Хэрэв хүсвэл, Гэм нүглээс Татгалзаж, Итгэлээ баталгаажуулах ёслолыг урд оруулж Усаар Талархал өргөж болно.

ГЭМ НҮГЛЭЭС ТАТГАЛЗАЖ, ИТГЭЛЭЭ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Эрт цагаас хойш Усан баталгааны Амлалт нь юун түрүүнд бузар муу бүхнээс татгалзаж улмаар итгэлээ баталгаажуулан Христэд итгэмжит байхаа илэрхийлэх явдлыг илэрхийлсээр ирсэн билээ.

Пастор чуулганд хандан хэлэхэд тэд эргэн хариулах хэлбэрээр явагдана. Үүнд:

Нийт Чуулганы нэрийн өмнөөс би та бүхнээс ийн асууж байна:

Та бүхэн бузар муу сүнсний хүч чадлыг хөсөр хаяж, энэ ертөнцийн хорон муугийн эрх мэдлээс татгалзаж, гэм нүглээ улайн гэмшиж байна уу?

Тийм ээ.

Та бүхэн хорон муу, шударга бус бүхний дарлалыг эсэргүүцэхэд Бурханаас өгөгдөж буй эрх чөлөө, хүч чадлыг хүлээн авч байна уу?

Тийм ээ.

Та бүхэн Есүс Христийг өөрийн Аврагч хэмээн хүлээн зөвшөөрч, өөрийн бүх найдвараа Түүний сүр жавхлант нигүүлсэлд даатгаж, түүнийг Өөрийн Эзэн болгон үйлчилж, бүх үндэстэн, ястан, бүх насны хүн төрөлхтөнд Христээс нээлттэй болгож өгсөн Сүм Чуулганы нэгэн хэсэг болохоо амлаж байна уу?

Тийм ээ.

Танд олгогдсон нигүүлслийн дагуу та бүхэн Христийн ариун Чуулганы итгэмжит гишүүн хэвээр үлдэж, энэ дэлхийд Христийн биет төлөөлөгчийн хувиар үйлчлэх үү?

Тэгнэ ээ.

Хүндэтгэлийн удирдагч эсвэл пастор итгэлийн баталгаажилт руу ийн удирдана:

Бүгдээрээ хамтдаа Хуучин болон Шинэ гэрээний Бичээст агуулагдсан Христ итгэлийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулцгаая.

Та Эцэг Бурханд итгэдэг үү?

**Би тэнгэр газрыг бүтээгч, аугаа хүчирхэг,
Ертөнцийн Эзэн Эцэгт итгэдэг.**

Та Есүс Христэд итгэдэг үү?

**Ариун Сүнсээр бүрэлдэж, онгон Мариас мэндэлсэн,
Понти Пилат захирагчийн үед зовж явсан,
цовлогдон нас барж оршуулагдаад
гурав хоногийн дотор үхлээс дахин амь орсон
тэгээд тэнгэрт одож, аугаа хүчирхэг
Ертөнцийн Эзэн Эцгийнхээ баруун гарын хүндэт суудалд заларсан,
дахин ирж үхсэн амьд бүх хүнийг шүүх
Түүний цорын ганц Хүү бидний Их Эзэн
Есүс Христэд би итгэдэг.**

Та Ариун Сүнсэнд итгэдэг үү?

**Би ариун Сүнсэнд итгэдэг.
Би ариун нэгдмэл цуглаан,
ариун хүмүүсийн нөхөрлөл,
гэмд үзүүлэх уучлал,
дахин амилалт болон
мөнхийн амьдралд итгэдэг.**

УСАН ДЭЭР ТАЛАРХАЛ ӨРГӨХ

Еслол, хүндэтгэлийн удирдагч энэ үед итгэлийн дахин баталгаажуулалт болгож нийт чуулганд харагдаж, сонсогдохоор тусгайлан бэлдсэн цөгц рүү ус юүлж болно.

Энэхүү залбирлыг пастор удирдан эхлүүлснээр хүмүүс нэгдэн орно. Ингэснээр сударт бичигдсэн Ариун Усан баталгааны утга учир, дүр төрхийг сэргээж буй хэрэг бөгөөд Ариун Зоогийн үеэрх Агуу Талархалтай нэгэн ижил юм. Бүгд босч зогсож болно.

Эзэн тантай хамт байх болтугай.

Мөн тантай ч бас хамт байх болтугай.

Бүгдээрээ залбирцгаая.

Пастор эртний Христчин залбирлын хэлбэрээр гараа өргөж болох ба нийт чуулганыг мөн адил тийн хийхийг урьж болно.

Мөнхийн Эцэг минь:

Эмх замбараагүй, эзгүй хоосноос

Та усыг урсгаж, гэрлийг бий болгосон билээ.

Ноагийн өдрүүдэд

Та усан онгоцыг уснаас авран гаргасан билээ.

Их үерийн дараа та үүлс дунд солонго татуулав.

Өөрийн хүмүүсээ Египетэд боолчлогдож байхыг хараад

Та тэднийг гүн тэнгисийн усыг гатлуулж эрх чөлөө рүү удирдсан билээ.

Тэдний үр хүүхдийг Иордан голыг гатлуулж

Та Өөрийн амласан газраа аваачсан билээ.

****Бүх газар дэлхий Эзэнд дуулагтун.**

Өдөр бүр Бурханы энэрлийг яригтун.

Өөрийн товлосон цагтаа Та Есүсийг илгээн,

эхийн хэвлийд байхаас нь өсгөн торниулсан.

Тэрээр Иоханаас баптисм хүртэж Таны Ариун Сүнсээр тослогдов.

Тэрээр өөрийн үхэл болон амилалалтыг баптисм дотор хуваалцаж,

Бүх үндэстнийг дагалдагч болгохоор

Өөрийн дагалдагчдаа дуудсан билээ.

****Христийн ажлыг үндэстнүүдэд тунхаглаж,**

Түүнийг алдрыг бүх хүн төрөлхтөнд зарлагтун.

Пастор усанд гараа дүрэх юм уу дээр нь тавьж усыг хутгаж эсвэл өргөж болно.

Өөрийн Ариун Сүнсээ цутгаж,

энэхүү усаар дамжуулан бидэнд усан баталгаан дотор хүртээсэн

Өөрийн нигүүлслийг дахин сануулаач.

Учир нь та бидний гэм нүглийг угаан арилгаж,
Амь амьдралыг минь бүхэлд нь зөв шударгаар хувцасласан юм.
Бид Христтэй хамт үхэж, дахин амилсан тул
Түүний ялалтыг эцсээ хүртэл тунхаглах болно.

****Тантай үргэлж хамт оршигч,
Таны Хүү Есүс Христээр дамжуулан
Мөнхийн Эцэг Та алдаршиг.
Үүрд мөнхөд оршиж, захирагч
Ариун Сүнс Таныг бүгд магтах болтугай. Амен.**

ИТГЭЛЭЭ БАТАЛГААЖУУЛАХ

Дахин баталгаажуулах үйл ажиллагаа нь дахин усан баталгаа хүртэж байгаа хэрэг биш юм. Чуулган Усан баталгааны Амлалтыг дахин баталгаажуулах үед хүндэтгэлийн удирдагч эсвэл пастор хүмүүсийг ус руу ирэхийг урьж ийнхүү хэлнэ:

Та бүхэн усан баталгаа хүртсэн гэдгээ дахин санаж талархагтун. **Амен.**

Усаар үйлдэх зан үйл нь дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

А. Усанд гараа дүрэн духан дээрээ загалмай зурах.

Б. Уснаас хутган авч цөгцөнд буцаан хийх

В. Уснаас хутган авч толгой, гар эсвэл нүүрэндээ хүргэх

Г. Ёслолын удирдагч эсвэл пастор болон бусад туслагчид шилмүүст модны мөчир эсвэл бусад зүйлийг усанд дүрэн авч чуулган руу цацаж болно. Энэ нь хиссопоор цэвэршүүлж буйтай ижил юм. (Египетээ гарсан нь 12:22, Дуулал 51:7) Мөн цацаж байгаа нь шинэчлэлийг бэлгэднэ. (Езекиел 36:25-26)

Пастор Усан Баталгааны амлалтыг баталгаажуулсан хүмүүст хандаж ийн хэлнэ:

Ус болон Сүнсээр дахин төрсөн та бүхний дотор Ариун Сүнс ажлаа хийж,

Та бүгд Есүс Христийн итгэмжит дагалдагч болон амьдрах болтугай.

Амен.

ТАЛАРХАЛ

Ёслол хүндэтгэлийн удирдагч эсвэл пастор чуулганыг талархал өргөхөд удирдана:

Амлалтандаа итгэмжит байгч Бурханд баярлан хөөрцгөөе.

Бидэнд аль хэдийн Бурханаас өгөгдсөн бүх зүйлд талархал өргөж байна.

Христийн биеийн нэгэн хэсэг,

Нэгдсэн Методист Цуглааны нэгэн гишүүн болохын хувьд

Бид Чуулганы үйлсэд залбирлаараа, ирцээрээ, авъяас билгээрээ

үйлчлэлээрээ, гэрчлэлээрээ итгэмжит байдлаар гар бие оролцон

Есүс Христээр дамжуулан Бурханыг алдаршуулах бүх зүйлсэд хүчин зүтгэх болно.

Пастор Усан Баталгааны Амлалтыг дахин баталгаажуулж буй олонд хандан хэлнэ:

Христ дотор мөнхийн алдар луу биднийг дуудсан,
бүх нигүүлслийн Бурхан
та бүхнийг Ариун Сүнсний хүчээр
босгон байгуулж, хүчирхэгжүүлдэг билээ.
Ингэснээр та бүхэн нигүүлсэл болон амар амгалан дотор амьдрах болтугай.
Амар амгалан нь та бүхэнтэй хамт байх болтугай.

Тохирох магтуу, шад шүлэг эсвэл хариу дууг дуулж болно. Христчин үүрэг, амлалтын тухай бусад магтуу дуу бас тохиромжтой.

Ихэвчлэн уг ёслолтой залган Ариун Зоогийн ёслолыг үйлдэх нь шүү тохиромжтой байдаг.
САНАА ТАВИЛТ БА ЗАЛБИРАЛ

Хүмүүс чуулган болон дэлхий ертөнцийн төлөө өөрсдийн холбогдох үйлчлэлийн талаар залбирлын сэдвүүд гаргана.

Пастор эсвэл залбирлын удирдагч ирсэн хүмүүсээс залбиралд оруулахыг хүссэн тодорхой

хэрэгцээ эсвэл талархлын сэдвийг асууж болно.

Залбирал нь эдгээр хэлбэрүүдийн нэг эсвэл түүнээс олон нь байж болно. Үүнд:

Тус тусын удирдагчдаараа удирдуулсан (удирдагч) чуулганы гишүүдийн товч гуйлт,

залбирал болон талархал. Эдгээр залбирлуудын төгсгөлд нийтээрээ “Эзэн, бидний залбирлыг сонсооч” зэрэг үгийг бүгдээрээ хэлэх эсвэл дуулж болно.

Гуйлт болон залбирлын мөргөл

Хүмүүсийн хэлсэн залбирлын сэдвүүдийг нэгтгэн пастороор удирдуулсан залбирал

Гэхдээ эдгээр залбирлууд нь хүмүүсийн хувийн асуудлаас гадна сүм чуулган, орон нутаг,

дэлхий нийт, итгэл, хүн төрөлхтөн, тэдгээрийн удирдагч, байгаль дэлхий зэрэг өргөн

хүрээний сэдвийг хамарсан байхаар удирдагч анхаарч чиглүүлнэ.

ХҮМҮҮСИЙН ЗАЛБИРАЛ

Хамтдаа залбирцгаая:

Энэ чуулганы хүмүүсийн төлөө... Эзэн, өөрийн энэрэл нигүүлсэл дотор **бидний залбирлыг сонсооч**

Зовж шаналж буй хүмүүсийн төлөө... Эзэн, өөрийн энэрэл нигүүлсэл дотор **бидний залбирлыг сонсооч**

Энэ орон нутгийн хүмүүсийн хэрэгцээний төлөө... Эзэн, өөрийн энэрэл нигүүлсэл дотор **бидний залбирлыг сонсооч**

Бидэнд хариуцуулж өгсөн байгаль дэлхийн төлөө... Эзэн, өөрийн энэрэл нигүүлсэл дотор **бидний залбирлыг сонсооч**

Бүх дэлхийн Чуулган, тэдгээрийн удирдагчид, итгэгчид, тэдний үйлсийн төлөө...

Эзэн, өөрийн энэрэл нигүүлсэл дотор

бидний залбирлыг сонсооч

Ариун хүмүүсийн нэгдлийн төлөө Эзэн, өөрийн энэрэл нигүүлсэл дотор
бидний залбирлыг сонсооч

ТАЛАРХАЛ БА ЗООГ

ТАЛАРХАЛ БУЮУ ЭЗЭНИЙ ШИРЭЭНД УРИХ

Хүмүүсийг Агуу их Талархал өргөхөд болон талархлын бусад хэлбэрт өөрсдийгөө зориулахад бэлтгэнэ.

Пастор эсвэл ёслолын удирдагч чуулганыг Агуу их Талархал болон талархлын бусад үйлийг өргөхөд өөрсдийгөө бэлдэхийг урьж гэм нүглээ улайн гэмших, өршөөл уучлалт гуйх болон бие биедээ Христийн амар амгаланг түгээх үйлд уриална.

ГЭМ НҮГЛЭЭ ГЭМШИХ, ӨРШӨӨЛ УУЧЛАЛТ ГУЙХ БОЛОН АМАР АМГАЛАНГ ТҮГЭЭХ

Хүмүүс өөрсдийн гэм нүглээ улайн гэмшиж Бурханаас өршөөл уучлалыг хүлээн авч, бие биедээ Христийн амар амгаланг түгээнэ.

УРИЛГА

Пастор эсвэл ёслолын удирдагч Эзэний ширээний ард зогсоно.

Бидний Эзэн Христ Өөрийг нь хайрлагч бөгөөд өөрсдийн гэм нүглийг үнэн сэтгэлээс улайн

гэмшиж, бие биедээ амар амгаланг хуваалцан амьдрахыг хүсэгч хүн бүрийг Өөрийн ширээнд урьж байна.

Иймд бүгдээрээ хамтдаа Бурханы өмнө болоод бусдын өмнө үйлдсэн гэм нүглээ гэмшицгээе.

ГЭМШИЛ БА ӨРШӨӨЛ *(Пастор эсвэл ёслолын Удирдагч бүгдийг залбиралд удирдана.)*

Өршөөлт Бурхан минь,

Бид Таныг өөрийн бүхий л зүрх сэтгэлээр хайрлаж чадаагүй гэм нүглээ улайн гэмшиж байна.

Бид чуулганы өмнө дуулгавартай байж чадаагүй.

Бид Таны хүслийг гүйцэлдүүлж чадаагүй.

Бид Таны хуулийг зөрчсөн.

Бид Таны хайрын эсрэг тэрсэлсэн.

Бид хөршөө хайрлаагүй.

Бид дорд хүмүүсийн хашгирахыг сонсоогүй.

Биднийг өршөөн уучлаач хэмээн залбирч байна.

Бидний Эзэн Есүс Христээр дамжуулан баяр баясгалант даруу байдал руу биднийг

чөлөөлөөч. Амен.

Бүгд чимээгүй залбирна.

Удирдагч хүмүүс рүү хандан:

Сайн мэдээг сонсогтун:

Биднийг гэмтэн байхад Христ бидний төлөө үхсэнээр
Бурхан биднийг хайрлах хайраа батлан харуулсан билээ.
Есүс Христийн нэрээр та бүгд уучлагдсан!

Удирдагч хүмүүс рүү хандан:

Есүс Христийн нэрээр та бүгд уучлагдсан!

Удирдагч хүмүүс рүү хандан:

Бурханд алдар нь байг! Амен.

АМАР ТАЙВАН

Бүгдээрээ хамтдаа бие биедээ эвлэрэл болон хайрыг харуулцгаая.

Пасторыг хамруулан бүгд Бурханы амар тайвны үгс болон бэлгэ тэмдгийг харилцан солилцоно.

ӨРГӨЛ

Уучлагдсан, эвлэрүүлэгдсэн хүмүүсийн хувьд

Бүгдээрээ хамтдаа өөрсдийгөө болон авчирсан бэлгээ Бурханд өргөл болгон өргөцгөөе.

Магтуу дуу, дуулал эсвэл сүлд дуулал өргөл өргөж байх үед эгшиглэж болно.

Итгэгчдийн төлөөллүүд Эзэний ширээ рүү талх болон дарсыг бусад бэлэгний хамт авчирна. Хэрэв аль хэдийн ширээн дээр байрласан бол бүтээлгийг авна.

Бэлгүүдийг өргөж байх үед магтуу дуу, ёслолын магтаал эсвэл бусад хэлбэрийн магтаал эгшиглэж болно.

Хэрэв Агуу их Талархлын ёслолыг үйлдэх бол энэ хэсгээс эхлэн үргэлжлүүлэх ба Үг ба Ширээний Үйлчлэл III (УМН 15-16) гэсний гарчиг болон дарааллын дагуу үйлдэгдэнэ. Хэрэв тус ёслолыг үйлдэхгүй бол дараах байдлаар үргэлжилнэ.

Хүмүүс авчирсан бэлгээ Бурханд өргөнө.

Ариун Зоогийн ёслолд зориулсан талх ба дарс
Хэрэгцээт хүмүүст туслахад зориулсан мөнгө эсвэл бусад эд зүйлс
Чуулганы үйлчлэлд дэмжлэг үзүүлэх мөнгө эсвэл бусад эд зүйлс
Дурсгалын бэлэг зэрэг бусад тохирох бэлгүүд

Бэлгүүдийг өргөж, хүлээн авч байх үеэр:

Дуу, магтуу дуу, сүлд дуулал, ёслолын магтаал зэрэг бусад урлагийн илэрхийллүүд эгшиглэж болно.

ТАЛАРХАЛ ӨРГӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүх бүтээлийг аврахын тулд Бурханы хийсэн болоод хийж байгаа, цаашид хийх зүйлсэд хүмүүсталархал өргөнө.

Талархал өргөх үйл ажиллагаа нь дараах зүйлсийг багтааж болно. Үүнд:

Талархлын харилцан залбирал

Бурханд талархал өргөх тухай нэг эсвэл түүнээс олон нийтийн магтаалын дуу
Хөгжмийн болоод бусад уран сайхны илэрхийллүүд

Аль ч хэлбэрээр өргөгдөж байгаа талархлууд нь Агуу их Талархлын ёслолын жишигийн дагуу явагдаж болох бөгөөд тэдгээр нь бүрэн цогц, Бүтээгч Гурвал Бурханаас хувь хүн, орон нутаг, дэлхий ертөнцийн төлөө болоод түүхэн хугацаанд хийгдсэн бөгөөд хийгдэж байгаа үйлсийг бүхэлд нь хамруулсан байна. Мөн Есүс Христ дотор амлагдсан бүх зүйлсийг болон авралыг тусгасан байна.

Талархлын Харилцан Залбирал

Бидний Эцэг Бурханаас бидэнд үнэгүй өгөгдсөн бүх Бэлгүүдийн төлөө талархал өргөцгөөе.

Газар дэлхий, тэнгэр, далай дахь таны бүтээлийн Гайхамшигт байдал, үзэсгэлэн төгөлдрийн төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Христийн дүр төрхийг илчлэн харуулж байгаа бүх эрчүүд болон эмэгтэйчүүдийн амьдралд танаас өгсөн нигүүлслийн баялгийн төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Бидний өдөр тутмын хоол унд, гэр орон, гэр бүл болоод найз нөхдийн төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Бодох ухаан, хайрлах сэтгэл хийгээд үйлчлэх гар бүхний төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Ажиллах хүч, эрүүл мэнд болон амарч тоглох зав чөлөөг олгосон тул
Эзэн, бид Танд талархаж байна.

Гай зовлонгийн дунд итгэмжит байж, шаналал бэрхшээлийн дунд тэвчээртэй байх эр зориг, урам чадлыг өгсний Тань төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Үнэн, эрх чөлөө, шударга ёсны төлөө баатарлагаар зогсогч бүхний төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Бүх цаг үеийн бүх газрууд дахь ариун хүмүүсийн нөхөрлөлийн төлөө
Эзэн, бид Танд талархаж байна.

Энэ бүгдээс илүү бидний Эзэн Христ Есүс дотор бидэнд өгөгдсөн аугаа их нигүүлсэл хийгээд амлалтуудын төлөө бид Танд талархал өргөж байна.

**Өө, Ариун Эцэг, Ариун Хүү, Ариун Сүнс Танд
Алдар болоод магтаал нь үеийн үед байх болтугай. Амен.**

ҮДЭЛТ

ЕРӨӨЛИЙН МАГТУУ ДУУ ЭСВЭЛ ҮДЭЛТИЙН МАГТАН ДУУ

Чуулган руу хандан эрх бүхий удирдагч Бурханы ивээлийг тунхаглана..

Ивээлийн үгийн урд эсвэл дараа нь магтуу дуу эгшиглэж болно.

Пастор, ёслолын удирдагч эсвэл өөр удирдагч нийт чуулганыг дэлхий ертөнц рүү үдэн гаргана.

ИВЭЭЛТЭЙ ҮДЭЛТ*

Амар амгалан дотор харих болтугай.

Та бүгдтэй Эзэн Есүс Христийн ивээл

Бурханы хайр

Ариун Сүнсний нөхөрлөл хамт байх болтугай. **Амен.**

ТАРАХ

Чуулган тарах үед дараахийн нэг эсвэл нэгээс илүүг хийж болно. Үүнд:

Хөгжмийн зэмсэгт хөгжим, чуулганыг тарахын өмнөх чимээгүй байдал, албан бус мэндчилгээ, харилцан ярилцлага болон нөхөрлөл

ОЮУНЫ ӨМЧ БОЛОН ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

“Нэгдсэн Методист Цуглааны Усан баталгааны Амлалтын Үйлчлэл, Зарчим болон Тогтоолын ном-2008 оны шинэчлэн зассан хувилбар” Зохиогчийн эрх © 2009, Нэгдсэн Методист Цуглааны Хэвлэлийн Газар. Нэгдсэн Методист Цуглааны Хэвлэлийн Газрын зөвшөөрөлтэйгөөр Дагалдагч бэлтгэх Ерөнхий Зөвлөлөөс хэвлэв.

Христчин чуулганууд болон сүм, чуулгантай холбоотой агентлагууд нь энэхүү бүтээлийг хүндэтгэл мөргөл, боловсролын зорилгоор хэвлэмэл болон электрон хэлбэрээр дараах зохиогчийн эрхийн мэдэгдлийн дагуу ашиглаж, хуулбарлаж дахин боловсруулж болно.

“Зарчим болон Тогтоолын Ном, 2008 оны шинэчлэн зассан хувилбар дахь Нэгдсэн Методист Цуглааны Усан баталгааны Амлалтын Үйлчлэл” Зохиогчийн эрх ©1976, 1980, 1985, 1989, 2009 Нэгдсэн Методист Цуглааны

1979 оны Эпископын Чуулганы Нийтлэг Залбирлын Номноос “Талархлын Мөргөл”. Нийтийн Эзэмшлийн

Энэхүү бүтээлийг Дагалдагч бэлтгэх Ерөнхий Зөвлөл болон Нэгдсэн Методист Хэвлэлийн Газрын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулах, худалдах болон аливаа цахим хуудсанд байршуулахыг хориглоно. Эдгээр болон бусад зорилгоор ашиглах зөвшөөрөл авахыг хүсвэл worship@gbod.org болон permissions@umpublishing.org и-мэйл хаягаар холбогдоно уу.



Open Hearts. Open Minds. Open Doors.

The people of The United Methodist Church®

DISCIPLESHIP MINISTRIES

General Board of Discipleship

THE UNITED METHODIST CHURCH